# МОНГОЛ УЛСЫН
# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
# ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
# ТУШААЛ

2025 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/56 Улаанбаатар хот

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дах хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө (2023-2032) батлагдсантай холбогдуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг салбарын төр, хувийн хэвшлийн компани, олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажлын явц, үр дүнг бүтэн жилээр Эрчим хүчний салбарын яамны дэргэдэх салбар зөвлөлд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Ж.Хичээнгүй)-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ

9021050999 СТС2130 5636009

1706000001**80**

Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны 4 дугаар сарын 22-ны
өдрийн А/56 тоот тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

| | |
|---|---|
| Ж.Хичээнгүй | Төрийн захиргааны удирдлагын газрын дарга |

Ажлын хэсгийн гишүүд

| | |
|---|---|
| Л.Мөнхцог | Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн ахлах шинжээч |
| Г.Гэрэлт-Од | Салбарын хяналтын газрын мэргэжилтэн |
| Л.Отгонжаргал | Санхүү хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч |
| Д.Цогоо | Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч |
| Д.Мөнхжаргал | “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн Хүний нөөц, бүтээмж хариуцсан менежер |
| Ш.Оюунгэрэл | “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Хууль, эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн |
| Н.Оюун-Эрдэнэ | “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Цахилгааны зураг төсөл, магадлал хариуцсан инженер |
| Л.Ганзориг | “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн Захиргаа удирдлагын албаны хүний нөөцийн мэргэжилтэн |
| Б.Амгалантуяа | “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК- ийн Техникийн бодлогын хэлтсийн Төслийн инженер |
| Б.Эрдэнээ | “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК- ийн Програмист, автоматикийн инженер |
| Д.Одончимэг | “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Нийгмийн асуудал, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн |
| Б.Солонго | “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хүний нөөцийн мэргэжилтэн |
| М. Доржханд | “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн төвийн бүсийн салбарын Чадамжийн төвийн сургагч инженер |
| П.Оюунтөгс | “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Бүтээмж хариуцсан мэргэжилтэн |
| Э.Цэвээнсүрэн | “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн Хөдөлмөрийн харилцааны мэргэжилтэн |
| Н.Уянга | Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн жендэрийн шинжээч /зөвшилцсөнөөр/ |
| Б.Анхбаяр | Митчелл Сангийн Жендерийн хөтөлбөрийн зохицуулагч /зөвшилцсөнөөр/ |

| | |
|---|---|
| Ч.Баяржаргал | “MCS интернэйшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөх /зөвшилцсноөр/ |
| Д.Ганцэцэг | Зөвлөх инженер, ахмад ажилтан /зөвшилцсноөр/ |
| Д.Эрдэнэбат | Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны эрчим хүч хариуцсан нарийн бичгийн дарга /зөвшилцсноөр/ |

Нарийн бичгийн дарга:

| | |
|---|---|
| Д.Оюунчимэг | Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч |
| Г.Гүнжлхам | “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Цех, нэгжийн тооцооны эдийн засагч |

БАТЛАВ: ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ

## ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилго, зорилт, үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Төсөв | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот Түвшин | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн | Хамтрагч |
| 0 | 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | **Зорилго 1. Салбарын удирдлага, ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх цогц үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1.1. | **Зорилт 1.1. Салбарын удирдлага, ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх ажиллагаа хэрэгжүүлнэ.** | - | - | - | - | - | - | - |
| 1.1.1 | **Үйл ажиллагаа 1.1.1** Эрчим хүчний салбарын байгууллагуудын жендэрийн өнөөгийн байдал, ЖЭТБ хэрхэн хангагдаж байгаа талаар судалгаа хийх | Салбарын байгууллагуудад судалгаа хийгдсэн ААНБ-ын тоо байна. | 0 | Тоо | 0 | 15 | Эрчим хүчний яам | Салбарын байгууллагууд |
| 1.1.2 | **Үйл ажиллагаа 1.1.2** ЖЭТБ-ыг хангах тухай хуулийн талаарх мэдээллийг ААНБ-ын дотоод сүлжээ болон хэвлэлд нийтлэх | Байгууллагын дотоод сүлжээ болон хэвлэл, олон нийтийн сүлжээнд байршуулсан ААНБ-ын тоо | - | Тоо | 0 | 28 | Эрчим хүчний яам | Салбарын байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | **Зорилт 1.2. Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж нэвтрүүлэх** | - | - | - | - | - | - | - |
| 1.2.1 | **Үйл ажиллагаа 1.2.1**<br>Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах | Үндэсний сургагч багш нар Удирдамж, хөтөлбөр боловсруулсан байна. | - | Тоо | 0 | 1 | Эрчим хүчний яам, Ажлын хэсэг | Салбарын байгууллагууд |
| 1.3 | **Зорилт 1.3 Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтыг зохион байгуулах** | - | - | - | - | - | - | - |
| 1.3.1 | **Үйл ажиллагаа 1.3.1**<br>Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан байгууллагын тоо байна. | - | Тоо | 0 | 15 | Эрчим хүчний яам, | Ажлын хэсэг |
| 2 | **Зорилго 2 Салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | **Зорилт 2.1 Салбарын жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг ААНБ, ИНБ-ын төлөөллөөр өргөтгөн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж, удирдамжаар хангах,** | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **яамны бодлого төлөвлөлтийн нэгжид жендэрийн орон тооны мэргэжилтэн, төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААНБ-д жендэрийн асуудал хариуцсан ажилтан ажиллуулах /хавсран гүйцэтгэж болно/** | | | | | | |
| 2.1.1 | **Үйл ажиллагаа 2.1.1** Төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААНБ-д жендэрийн асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолт батлуулж ажилтан томилоход удирдамж чиглэл хүргүүлэх /МУ-н Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны даргын 2025.02.04-ний өдрийн Жендэрийн үндэсний хорооны хуралдааны тогтоол №3-н дагуу/ | Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудад жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнг томилсон байна. | - | Тоо | 0 | 20 | Эрчим хүчний яам, | Салбарын байгууллагууд |
| 2.2 | **Зорилт 2.2 Салбарын ААНБ-ын шийдвэр гаргах бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох удирдамж гарган мөрдүүлнэ.** | - | - | - | - | - | - | - |
| 2.2.1 | **Үйл ажиллагаа 2.2.1** Эрчим хүчний салбарын төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулах | Салбарын төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулсан байна. | - | Тоо | 0 | 10 | Эрчим хүчний яам, | Салбарын байгууллагууд |
| **3** | **Зорилго 3 Салбарын төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагын ажилтанд жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин нөхцөл бүрдүүлэх, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш үр шим хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.** | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | **Зорилт 3.1. Эрэгтэй ажилтны дундаж наслалтын судалгааг гаргаж, нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх (эрүүл хоол хүнс хэрэглэх, хорт зуршлыг арилгах) зөвлөмж гаргана.** | - | - | - | - | - | - | - |
| 3.1.1 | **Үйл ажиллагаа 3.1.1** Хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтын судалгаа гаргах | Салбарын байгууллагуудад судалгаа хийгдсэн байна. | - | Судалгаа хийгдсан тоо | 0 | 20 | ЭХЯ, Ажлын хэсэг | Салбарын байгууллага |
| 3.1.2 | **Үйл ажиллагаа 3.1.2** Хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж дүгнэлт гаргах | Дүгнэлт хийгдсэн байна. | - | Тоо | - | 1 | ЭХЯ, Ажлын хэсэг | Салбарын байгууллага |
| 3.2 | **Зорилт 3.2. ЖЭТБХ тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид ногдуулсан үүргийн хэрэгжилтийг хангуулж, ААНБ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилнэ.** | - | - | - | - | - | - | - |
| 3.2.1 | **Үйл ажиллагаа 3.2.1** Эрчим хүчний салбарын байгууллагын дотоод журамд ЖЭТБ тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид ногдуулсан үүргийн хэрэгжилтийг хангуулах талаарх заалтыг тусгах | Салбарын төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулсан байна. | - | Тоо | 0 | 10 | Эрчим хүчний яам, | Салбарын байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Зорилго 4 Жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах боломж бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | **Зорилт 4.1. Эрчим хүчний салбарын ААНБ-ын дотоод журам болон цаг бүртгэлийн журамд жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд ажлын цагийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгах** | - | - | - | - | - | - | - |
| 4.1.1 | **Үйл ажиллагаа 4.1.1** Салбарын ААНБ-ын дотоод журам болон цаг бүртгэлийн журамд жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд ажлын цагийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх | Салбарын төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулсан байна. | - | Тоо | 0 | 10 | Эрчим хүчний яам, | Салбарын байгууллагууд |
| 4.1.2 | **Үйл ажиллагаа 4.1.2** Салбарын ААНБ-ын дэргэд хүүхдийн цэцэрлэг, өдөр өнжүүлэх ажиллуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ. | Байгууллагын дэргэдэх хүүхдийн өрөө, цэцэрлэг ажиллуулсан байна. | - | Тоо | 0 | 5 | ЭХЯ, ТбХХ-ийн ААНБ | Салбарын байгууллага |

Танилцсан:

Ажлын хэсгийн дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ж.Хичээнгүй

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий

Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох

Хяналт- шинжилгээ үнэлгээ,дотоод аудитын газрын дарга Х.Бекболат

Салбарын хяналтын газрын дарга П.Билгүүн

Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И. Лувсанцэрэн

Санхүү,хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт

Нэгтгэн боловсруулсан:

Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд

Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч Д.Оюунчимэг